

2024~2025

Сөүлийн Үндэсний Их Сургууль
Хэлний боловсролын төв
Солонгос хэлний бэлтгэл



The Korean Language Program



Сөүлийн Үндэсний Их Сургууль Хэлний Боловсролын Төв Солонгос хэлний бэлтгэл

Сөүлийн Үндэсний их сургууль нь дэлхийд тэргүүлэгч, бүтээлч мэдлэгийн нийгмийг бий болгох зорилго бүхий үндэсний их сургууль бөгөөд 1946 онд БНСУ-ын андагч улсын нэгдсэн их сургууль болон байгуулагдсан түүхтэй. Түүнээс хойш 70 гаруй жилийн хугацаанд төрөл бүрийн сургалт, судалгаа мөн тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон тохилог кампус Сөүлийн Үндэсний их сургуулийн эрдэмтэн багш нар, окутан судлаачид сургалт, судалгаа шинжилгээний ажилд идэвхтэй оролцсоор ирсэн юм. Сөүлийн Үндэсний их сургууль нь 2023 онд QS Дэлхийн их сургуулийн зэрэглэл(QS World University Rankings)-ээр дэлхийд 29-р байр, Азид 17-р байранд орсон зэрэг Солонгос улсдаа төдийгүй Азийн гол их сургууль, дэлхийн тэргүүлэх их сургуулиудын нэг хэмээн тооцогдож байна.

Хэлний боловсролын төвийн захирлын мэндчилгээ

Сайн байцаана уу?

Сөүлийн Үндэсний их сургуулийн Хэлний боловсролын төв Солонгос хэлний бэлтгэлийг сонирхож буй та бүхэнд талархал илэрхийлье.

Сөүлийн Үндэсний их сургуулийн Хэлний боловсролын төвийн солонгос хэлний бэлтгэл нь 1969 онд байгуулагдсан цагаасаа хойш хагас зууны турш гадаадын иргэд болон хилийн чанад дахь солонгосчууд, Солонгос улс дахь цагаачдад зориулан солонгос хэл, соёлын сургалтаа явуулж байна.


Тус төвийн багшлах бүрэлдэхүүн нь солонгос хэлний боловсрол, холбогдох онолын чиглэлээр мэргэшсэн магистр болон түүнээс дээш зэрэгтэй багш нараас бүрддэг. БНСУ-ын солонгос хэлний боловсролын шилдэг мэргэжилтэн хэмээн бахархалтайгаар хэлж чадах манай багш нар олон жилийн арвин туршлага, солонгос хэлний боловсролын салбарын судалгааны шилдэг ололт амжилтуудаа тулгуурлан гадаад суралцагчдын олон талт хэрэгцээг харгалзан сургалтын оновчтой арга, хөтөлбөрөөр хангахаар хичээн ажиллаж байна.

Солонгос хэлний бэлтгэл төв нь орчин үеийн боловсролын байгууламж, тав тухтай тохилог орчин гээд сургалтын хамгийн сайхан орчныг бүрдүүлсэн. Солонгос уур амьсгалыг мэдрэх боломжтой төв цэцэрлэгийг тойрсон байрласан 2 хичээлийн байранд интернэтэд суурилсан мультимедиа хичээл явуулах боломж бүхий орчин үеийн анги танхим, номын сан, сургалтын дараа хичээл хийх анги, амралтын өрөө, кафе, цайны газар гэх мэт тав тухтай барилга байгууламжтай.

Сөүлийн Үндэсний их сургуулийн Хэлний боловсролын төвийн Солонгос хэлний бэлтгэлд та бүхнийг урьж байна. Тус Хэлний бэлтгэлийн шилдэг солонгос хэлний хөтөлбөрөөр солонгос хэл сурч, төрөл бүрийн соёлын хөтөлбөрөөр дамжуулан солонгос соёлын талаар ойлголттой болохыг хүсье. Үүний зэрэгцээ дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн гадаад найзүүдтэй болж, Солонгос улс болон солонгос хэлний ертөнцийг гайхалтайгаар мэдрэхийг хүсье.

Баярлалаа.

Сөүлийн Үндэсний их сургуулийн Хэлний боловсролын төвийн захирал



01

Regular Programs

Үндсэн сургалт

Энэхүү сургалт нь харилцааны чадварт төвлөрсөн, солонгос хэлийг цогцоор нь сурах зорилготой суралцагчдад зориулсан бүтэн жилийн хөтөлбөр юм. Солонгос хэлийг эрчимжүүлсэн байдлаар сурч бакалавр, магистр, докторт дэвшин суралцах болон солонгостой холбоотой бизнес эрхлэх, ажилд орох зорилготой гадаад суралцагч, хилийн чанад дахь солонгосчууд, солонгос дахь цагаачдад зориулагдсан сургалт юм. 1-6 түвшин хүртэл нийт 6 түвшинтэй ба түвшин тус бүр нь нийт 10 долоо хоногийн 200 цаг солонгос хэлээр харилцах чадварыг нэмэгдүүлж, мөн төрөл бүрийн соёлын арга хэмжээнд оролцоно. Анги дүүргэлт 12-16 суралцагчтай байх ба шилдэг суралцагчид тэтгэлэг олгодог. Үндсэн сургалтад бүртгүүлсэн суралцагч сургуулийн дотуур байр болон хэлний бэлтгэлийн виз(D-4)-нд хүсэлт гаргах боломжтой.

Мөн үндсэн сургалтын 6-р түвшнээс дээш түвшний солонгос хэлний сургалтад хамрагдсан болон түүнтэй дүйцэх солонгос хэлний мэдлэгтэй суралцагчдад зориулсан судалгааны анги нь бакалавр, магистр, докторын хичээлд хэрэгтэй төрөл бүрийн хэлний чадвар, ажил эрхлэхэд хэрэгтэй соёлын орчин болон мэргэжлийн хэлний чадварыг нэмэгдүүлэх боломжтой.

Үндсэн сургалт	Анхан	Дунд	Дээд	Судалгааны анги
	1 түвшин / 2 түвшин	3 түвшин / 4 түвшин	5 түвшин / 6 түвшин	

Улирал
Хичээлийн
цаг

Хавар, Зун, Намар, Өвөл, Жилд 4 улирал, тус бүр 10 долоо хоногийн сургалт
[Үдээс өмнөх анги] Даваа-Баасан 09:00-13:00 (Нийт 200цаг/улиралд)
[Үдээс хойших анги] Даваа-Баасан 13:30-17:20 (Нийт 200цаг/улиралд)
[Судалгааны үдээс өмнөх анги] Даваа-Пүрэв 09:00-13:00 (Нийт 160цаг/улиралд)
[Судалгааны үдээс хойших анги] Даваа-Пүрэв 13:30-17:20 (Нийт 160цаг/улиралд)
[Үдээс өмнөх анги] 1,800,000вон [Үдээс хойших анги] 1,650,000вон
[Судалгааны үдээс өмнөх анги] 1,450,000вон
[Судалгааны үдээс хойших анги] 1,320,000вон

Сургалтын
төлбөр

* Бүх ангийн сургалтын төлбөр жил бүр урьдчилан мэдэгдэхгүйгээр өөрчлөгдөх магадлалтай. Та заавал манай цахим хуудаснаас баталгаажуулж харна уу.

✓ Солонгос хэлний бэлтгэлийн соёлын хөтөлбөр

Солонгос хэлний сургалтын агуулгатай холбоотой төрөл бүрийн соёлын үйл ажиллагаагаар дамжуулан бодит солонгос хэл болон солонгос соёлд суралцана.

- Таеквондо, тариагчдын дөрвөл хөгжим, солонгос хоол, цаасан урлал сурах
- Тоглолт үзэх, Панмүнхжом, сонины газар, Хөх ордны аялал
- Эртний ордон, музей, Чонгечон, Ханок тосгон зэрэг Сөүлийн алдартай газруудаар очиж үзэх

✓ Хамтрагчийн хөтөлбөр

Сөүлийн Үндэсний их сургуульд сурч буй оюутнууд болон солонгос хэлний багш бэлтгэх сургалтын суралцагчдаас бүрдсэн хамтрагчдыг тус хэлний бэлтгэлийн гадаад оюутнуудтай 1:1-р холбож өгдөг солонгос хэлний хамтрагчийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Хамтрагчид нь гадаад оюутнуудтай тогтмол уулзаж, солонгос хэл сурах, солонгосын нийгэмд дасан зохицоход нь тусална.

✓ Сонгон анги

Суралцагч бүрийн хэрэгцээ шаардлагыг хангахын тулд үндсэн сургалтаас гадна сонгон ангийг төлбөртэйгөөр хичээллүүлж байна

- Ханзны анги, Солонгос хэлний түвшин тогтоох шалгалт(ТОPIK)-д бэлтгэх анги

* Цөөн хүн бүртгүүлсэн тохиолдолд тухайн анги нээгдэхгүй байх магадлалтай.



Шихын кампусын салбар

✓ Смарт солонгос хэлний сургалт

Энэхүү сургалт нь эрчимжүүлсэн солонгос хэлний сургалтаар дамжуулан бакалавр, магистр, докторт дэвшин суралцах болон бизнес эрхлэх, ажилд орох зорилготой суралцагчдад зориулсан бүтэн жилийн хөтөлбөр юм.

Смарт солонгос хэлний сургалт	Анхан	Дунд	Дээд
	1 түвшин /2 түвшин	3 түвшин /4 түвшин	5 түвшин /6 түвшин

Улирал
Хичээлийн цаг
Сургалтын төлбөр

Жилд 4 улирал, 10 долоо хоногийн сургалт
Даваа-Баасан 9:00-12:50(нийт 200 цаг/улиралд)
1,600,000вон

※ Шихын кампусын сургалтын төлөвлөгөөг цахим хуудаснаас харна уу.

02

KOREAN LANGUAGE TEACHER TRAINING PROGRAM

Солонгос хэлний багш бэлтгэх хөтөлбөр

Энэхүү хөтөлбөр нь гадаад болон дотоодод солонгос хэлний сургалт явуулах замаар солонгос хэлний даяарчлал, гадаад, дотоодын солонгос хэлний боловсролын түвшнийг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах мэргэжилтэн бэлтгэн гаргадаг сургалт юм. Эх хэлний суурь хуульд заасны дагуу солонгос хэлний багшийн шалгуурыг хангах солонгос хэл судлал, ерөнхий хэл шинжлэл, гадаад хэл-солонгос хэл заах аргазүй зэрэг онолын хичээлүүдээс гадна ажиглах дадлага, багшлах дадлага зэрэг системтэй дадлагуудыг хийлгэдэг. Тус хөтөлбөрийн төгсөгчид одоо Сөүлийн Үндэсний Их Сургуулийн Хэлний боловсролын төв тэргүүтэй дотоодын солонгос хэлний боловсролын байгууллага, мөн гадаадад ч идэвхтэй ажиллаж байна.

Хөтөлбөрийн танилцуулга

Хавар : намрын үндсэн анги 15 долоо хоног(нийт 130цаг) Даваа, Лхагва, Баасан 18:30-22:00

Зун : Өвлийн тусгай анги 5 долоо хоног(нийт 130цаг) Даваа, Лхагва, Баасан 9:30-17:20 / Мигмар, Пүрэв 13:30-17:20

Солонгос хэл судлал, Ерөнхий хэл шинжлэл, Хэрэглээний хэл шинжлэл, Гадаад хэл-солонгос хэл заах арга зүй, Солонгос соёл, Солонгос хэлний багшлах дадлага

Сөүлийн Үндэсний Их Сургуулийн багш, Тус хэлний бэлтгэлийн үндсэн багш, солонгос хэлний боловсролын салбарын мэргэжилтэн

Төхөөмөн хичээл, Багшлах дадлага, Ажиглах дадлага, дадлага хичээл, оюутан удирдах дадлагын үйл ажиллагаа гэх мэт

Бүрэн дүнд сургууль төгссөн болон түүнтэй дүйх боловсрол эзэмшигч
※ Гадаад хүний хувьд гараад болон дотоодын бакалавраас дээш(4 жилийн) зэрэгтэй, эхэл дараах 4 бэлтгэл нэг болон түүнээс дээш болгон хангасан хүн

- ТОРЖ 6 түвшинтэй байх
- Солонгос дахь солонгос хэлний байгууллагын үндсэн ангийн 6-р түвшин төгссөн байх
- Өөрийн улсад солонгос хэлний чиглэлийн мэргэжлээр их, дээд сургууль төгссөн байх
- Солонгос бакалавр(4 жилийн сургалттай)-аас дээш зэрэг авсан байх

- Онцгой хусалт : Тус Хэлний бэлтгэлийн цэврийн хуудас(ielts.ac.kr/ielts) -наас онцгой хусалт гаргах
- ※ Шуудангаар болон биечлэн бүртгэхүй болно.
- Суралцах төлөвлөгөө
- Сүүлд төгссөн сургуулийн дунгийн хуудал, төгсөлийн гэрчигээ
- Бүртгэлийн хураамж : 30,000вон (буцаан олгоггүй)
- Бүрдүүлсэн бичиг : Барилмыг буцаан олгоггүй болно.

Бүрдүүлэх бичиг баримт

Сургалтын төлбөр

1,500,000вон

03

SPECIAL PROGRAMS

Тусгай сургалт

✓ Оройн анги

Өдөр тутмын амьдралд хэрэгтэй суурь солонгос хэлний харилцааны чадвараа сайжруулах хүсэлтэй насанд хүрэгчдэд зориулсан хөтөлбөр.

Улирал

Хавар, Зун, Намар, Өвөл Жилд 4 улирал, тус бүр 10 долоо хоног

Хичээлийн цаг

Даваа, Пүрэв 18:30-21:20 (Нийт 60цаг/улиралд) 660,000вон

Сургалтын төлбөр

※ Анги бүрдээгүй тохиолдолд ичвэл цуцлагдах магадлалтай

✓ 13 долоо хоногийн солонгос хэлний сургалт

Солилцооны окутан болон визтэй энгийн суралцагчдын хэрэгцээ шаардлага, онцлогт тааруулсан сургалт бөгөөд сургуулийнхаа хичээлийн улиралтай нийцүүлэн 13 долоо хоногийн хугацаатай явуулдаг. Сургалтын агуулгын ачаалал бага, сурсан агуулгаа хангалттай эзэмшиж, ашиглаж чаддаг болгох зорилготой.

Улирал

Хавар, намар; Жилд 2 улирал, улирал тус бүр 13 долоо хоног

Хичээлийн цаг

Даваа, Лхагва, Баасан 09:00-12:00 (Нийт 117 цаг)

Сургалтын төлбөр

1,150,000 вон

✓ 3 долоо хоногийн цахим сургалт

Энэхүү сургалт нь солонгос хэлний хичээлийг 3 долоо хоногт шууд цахимаар олгох хөтөлбөр юм.

Хичээлийн цаг

Даваа-Баасан 09:00-11:50 (Нийт 45цаг)

Сургалтын төлбөр

470,000вон

※ 3 долоо хоногийн цахим сургалтын хичээлийн хуваарь болон сургалтын төлбөрт өөрчлөлт орох магадлалтай. Цахим хуудаснаас харна уу.

04

TAILORED PROGRAMS

Итгэмжлэгдсэн сургалт

- 1 Малайзын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөр
- 1 DLI(Defence Language Institute) солонгос хэлний хөтөлбөр
- 1 Японы Кэйю их сургуулийн богино хугацааны сургалтын хөтөлбөр
- 1 Японы Токиогийн их сургуулийн богино хугацааны сургалтын хөтөлбөр
- 1 Сөүл дэх Япон сургуулийн багш нарт зориулсан солонгос хэлний хөтөлбөр
- 1 Спортын зохион байгуулагчийн хөтөлбөр
- 1 Соёлын түнш солонгос хэлний сургалтын хөтөлбөр
- 1 АНУ Йеллийн их сургуулийн Light fellowship хөтөлбөр
- 1 ITRP солонгос хэлний сургалтын хөтөлбөр(Шийн кампусын салбар)



Хүсэлт гаргах болон бүртгэл

Хүсэлт гаргах эрх

Бүрэн дунд сургууль төгссөн, эсвэл үүнтэй дүйцэх боловсрол эзэмшигч

Бүрдүүлэх бичиг баримт

Онлайн хүсэлт : Хэлний бэлтгэлийн цахим хуудас(ie.snu.ac.kr/klcc)-аас 'Онлайн хүсэлт гаргах

	Онлайн хүсэлт	Суралцах төлөвлөгөө	Анкет болон өөрийн танилцуулга	Хамгийн сүүлд төгссөн сургуулийн дүнгийн тодорхойлолт болон төгсөлтийн гэрчилгээ	Гадаад паспортын хуулбар	Банкны баталгаа	Photocopy of Insurance Certificate	Application Fee (Non-refundable)
Үндсэн сургалт (үдээс өмнөх анги, үдээс хойших анги)	o	o	o	Дээрх бүх бичиг баримт.	o	o Анхаарах зүйлсийг харна уу		60,000вон
Оройн сургалт	o			o	o		o	30,000вон
13 долоо хоногийн солонгос хэлний сургалт	o			o	o		o	60,000вон
3 долоо хоногийн цахим сургалт	o			o	o			30,000вон
Смарт солонгос хэлний сургалт(Шийн кампус)	o	o	o	Дээрх бүх бичиг баримт	o	o		60,000вон

- * Шуудангаар болон биечлэн бүртгэхгүй болно.
- * Бүрдүүлсэн бичиг баримтыг огт буцаан олгохгүй болно.
- * Хэлний боловсролын төв нь виз(D-4) хүсэлтийг хариуцахгүй болно.

* Үндсэн сургалтад бүртгүүлэхэд анхаарах зүйлс

(1) Суралцах төлөвлөгөө

Солонгос хэлний сургалтад суралцах хүсэлт гаргаж буй шалтгаан, төгссөний дараах төлөвлөгөөний талаар тодорхой бичих. Солонгос хэл, англи хэл, хятад хэл, япон хэлний аль нэгээр бичиж өгөх. А4 нэг нүүрэнд багтаах. Загвар тусдаа байхгүй чөлөөтэй бичих.

(2) Анкет болон өөрийн танилцуулга

Ахлах ангисаас хойших боловсролын байдал болон бусад ажлын туршлагыг талар товчлон бичих. Солонгос хэл, англи хэл, хятад хэл, япон хэлний аль нэгээр бичиж өгөх. А4 нэг нүүрэнд багтаах. Загвар тусдаа байхгүй чөлөөтэй бичих.

(3) Хамгийн сүүлд төгссөн сургуулийн төгсөлтийн гэрчилгээний эх хувийг сканердаж өгөх.(Солонгос хэл, англи хэл, хятад хэл, япон хэлний аль нэг хэлээр байх. Бусад хэл дээрх бичиг баримтын орчуулгын нотариатаар батлуулсан хувийг сканердаж эх хувийн сканердсан хувьтай хамт өгөх.)

②Хамгийн сүүлд төгссөн сургуулийн нийт дүнгийн хуулганы эх хувийг сканердаж өгөх.(Солонгос хэл, англи хэл, хятад хэл, япон хэлний аль нэг хэлээр байх. Бусад хэл дээрх бичиг баримтын орчуулгын нотариатаар батлуулсан хувийг сканердаж эх хувийн сканердсан хувьтай хамт өгөх.)

③Хамгийн сүүлд төгссөн сургуулийн төгсөлтийн гэрчилгээ болон дүнгийн хуулганы apostille гэрчилгээ(Apostille) өгөх. Apostille-н гшдүүн бус орон бол БНСУ-ын консулын газраас консулын баталгаа авах ёстой.

* Хятад улсын иргэний бүрдүүлэх бичиг баримт(Гайвань, Хонконг хамааралгүй)

- 1) Хамгийн сүүлд төгссөн сургуулийн төгсөлтийн гэрчилгээний эх хувийн сканердсан хувь
- 2) Хамгийн сүүлд төгссөн сургуулийн нийт дүнгийн хуулганы эх хувийн сканердсан хувь
- 3) Хамгийн сүүлд төгссөн сургуулийн төгсөлтийн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар: Боловсролын яамнаас олгосон боловсролын гэрчилгээний эх хувийг татаж аваад хавсаргана уу.

Боловсролын гэрчилгээний веб хуудас www.chsi.com.cn, www.cdgdc.edu.cn-naas(Ахлах сургуулийн төгсөлтийн гэрчилгээ нь www.chsi.com.cn-c-l баталгаажуулах боломжтой) батлуулах болон нотариатаар батлуульсны дараа БНСУ-ын Консулын газраас консулын баталгаа

4) Хамгийн сүүлд төгссөн сургуулийн нийт дүнгийн хуулганы баталгаажуулсан хуулбар: Боловсролын яамны баталгаажуулсан эх хувийг татаж аваад хавсаргана уу. Баталгаажуулалтын веб хуудас www.chsi.com.cn, www.cdgdc.edu.cn -с батлуулах болон нотариатаар баталгаажуульсны дараа БНСУ-ын Консулын газраас консулын баталгаа

* Хамгийн сүүлд төгссөн сургуулийн дүнгийн хуулганы баталгаажуулсан хувилбар нь хүсэлтийн Төгсөлтийн гэрчилгээ болон дүнгийн хуулганы apostille, БНСУ-ын Консулын газрын консулын баталгаа хэсэгт хавсаргана уу.

5) Ахлах сургуулийн төгсөх ангийн сурагчийн хувьд(төгсөгчид хамааралгүй): Төгсөх ангийн сурагч гэсэн тодорхойлолтын эх хувийн сканердсан хувилбар болон дүнгийн хуулганы баталгаажуулсан хувилбарыг өгөх. Дүнгийн хуулгыг боловсролын гэрчилгээний баталгаажуулалтын веб хуудас болох www.chsi.com.cn, www.cdgdc.edu.cn батлуулах юмуу нотариатаар баталгаажуульсны дараа БНСУ-ын Консулын газраас консулын баталгаа

www.cdgdc.edu.cn-c батлуулах юмуу нотариатаар баталгаажуульсны дараа БНСУ-ын Консулын газраас консулын баталгаа

(4) Банкны баталгаа(D-4 виз шаардлагагүй бол алгасах боломжтой)

① Өөрийн нэр дээрх данс байх. Эцэг эхийнээ нэр дээрх дансны баталгааг өгөх тохиолдолд төрөл садангийн лавлагаа өгөх.

② 10 сая вонноос дээш, 30 хоногийн дотор авсан хуулга байх

*Хятад оюутны хувьд

Хятадаар 6 сараас дээш хугацаагаар хөдөлгөөнгүй байршуулах.

*Вьетнам оюутны хувьд

1) 3 сараас дээш хөдөлгөөнгүй байршуулсан дансны үлдэгдлийн лавлагаа

2) Гадаадад суралцах зардлын барьцааны батлан даалт

*Узбекистан оюутны хувьд

Узбекистан дахь Солонгос санхүүгийн байгууллагаас 3 сараас дээш хөдөлгөөнгүй байршуулсан дансны үлдэгдлийн лавлагаа

③ Солонгос хэл, англи хэл, хятад хэл, япон хэлний аль нэг хэлээр байх. Бусад хэл дээрх бичиг баримтын орчуулгын нотариатаар батлуулсан хувийг сканердаж эх хувийн сканердсан хувьтай хамт өгөх.

Элсэлт

Онлайн хүсэлт гаргах▶Бичиг баримтын шалгалт▶Бичиг баримтын шалгалтын харууг зарлах болон бүртгүүлэх дарааллын талаарх мэдээлэл▶Төлбөр төлөх▶Хичээлийн нээлтийн мэдээлэл▶Түвшин тогтоох шалгалт▶Хичээл эхлэх

Тэнцсэн оюутны бүртгэл

Цахим кредит картаар төлбөр төлөх эсвэл тусгай данс цахим хуудас(ie.snu.ac.kr/klcc)-аар дамжуулан төлбөр төлөх боломжтой.

*Бүртгэлээ цуцлах, төлбөр буцаалт, бүртгэлээ хойшлуулах талаар тус Хэлний бэлтгэлийн цахим хуудаснаас лавлаж харна уу.

2024 Сургалтын төлөвлөгөө

	Улирал	Хугацаа	Бүртгэл хаагдах	Хариу гарах(e-mail)	Түвшин тогтоох шалгалт
Үндсэн сургалт	Хавар	3.4 – 5.10	12.21(Пүрэв)	1.8(Даваа) 17цаг	2 сарын дундуур
	Зун	6.3 – 8.9	3.25(Даваа)	4.8(Даваа) 17цаг	5сарын дундуур
	Намар	9.2 – 11.8	6.24(Даваа)	7.8(Даваа) 17цаг	8сарын дундуур
	Өвөл	12.2 – 2025.2.7	9.20(Баасан)	10.7(Даваа) 17цаг	11сарын дундуур
Тусгай сургалт	Оройн анги		Визтэй хүмүүст зориулагдсан.		
	Хавар	3.4 – 5.9	2.2(Баасан)	2.8(Пүрэв) 17цаг	2 сарын дундуур
	Зун	6.3 – 8.8	5.3(Баасан)	5.10(Баасан)17цаг	5сарын дундуур
	Намар	9.2 – 11.7	8.2(Баасан)	8.9(Баасан)17цаг	8сарын дундуур
	Өвөл	12.2 – 2025.2.6	11.1(Баасан)	11.8(Баасан)17цаг	11сарын дундуур
	3 долоо хоногийн цажим сургалт				
	Хавар	2.12 - 3.1	1.5(Баасан)	1.9(Мягмар)	1 сарын дундуур
	Зун	8.12 - 8.30	6.28(Баасан)	7.2(Мягмар)	7 сарын дундуур
	13 долоо хоногийн солонгос хэлний сургалт		Визтэй хүмүүст зориулагдсан.		
	Хавар	3.4 – 5.31	1.26(Баасан)	2.2(Баасан) 17цаг	2 сарын дундуур
Намар	9.2 – 11.29	7.26(Баасан)	8.2(Баасан) 17цаг	8 сарын дундуур	
Солонгос хэлний багш бэлтгэх сургалт	Хавар	3.4 – 6.19 (15 долоо хоног)	2.2(Баасан) 13цаг	2.5(Даваа)	
	Зун	6.24 – 8.2 (6 долоо хоног)	5.24(Баасан) 13цаг	5.27(Даваа)	
	Намар	9.2 – 12.11 (15 долоо хоног)	8.2(Баасан) 13цаг	8.5(Даваа)	
	Өвөл	2025.12 - 2.14 (6 долоо хоног)	11.29(Баасан) 13цаг	12.2(Даваа)	

※ Хэлний бэлтгэлийн нөхцөл байдлаас шалтгаалан зарим нэг төлөвлөгөө өөрчлөгдөж болно.



Korean Language Education Center
Seoul National University

08826 Сеул хот Гванак дүүрэг Гвангагу 1
Сеулийн Үндэсний Их Сургуулийн Хэлний боловсролын төв Солонгос хэлний бэлтгэл 137 байр 101 тоот

Phone : +82-2-880-5488, 8570 Fax : +82-2-871-6808

E-mail : klp@snu.ac.kr

Website : leisu.snu.ac.kr

137 байр, Хэлний боловсролын төвийн төв байр(Солонгос хэлний бэлтгэл)

137-1 байр, Хэлний боловсролын төвийн шинэ байр(С) хэлний сургалтын байр)

137-2 байр, Хэлний боловсролын төвийн Дарим олон улсын байр

2025 Сургалтын төлөвлөгөө

	Улирал	Хугацаа	Бүртгэл хаагдах	Хариу гарах(e-mail)	Түвшин тогтоох шалгалт	
Үндсэн сургалт	Хавар	3.3 – 5.9	12.19(Гүрэв)	1.6(Даваа) 17цаг	2 сарын дундуур	
	Зун	6.2 – 8.8	3.24(Даваа)	4.7(Даваа) 17цаг	5сарын дундуур	
	Намар	9.1 – 11.7	6.23(Даваа)	7.7(Даваа) 17цаг	8сарын дундуур	
	Өвөл	12.1 – 2026.2.6	9.22(Даваа)	10.13(Даваа) 17цаг	11сарын дундуур	
Тусгай сургалт	Оройн анги		Визтэй хүмүүст зориулагдсан.			
	Хавар	3.3 – 5.8	1.31(Баасан)	2.7(Баасан) 17цаг	2 сарын дундуур	
	Зун	6.2 – 8.7	5.2(Баасан)	5.9(Баасан) 17цаг	5сарын дундуур	
	Намар	9.1 – 11.6	8.1(Баасан)	8.8(Баасан) 17цаг	8сарын дундуур	
	Өвөл	12.1 – 2026.2.5	10.31(Баасан)	11.7(Баасан) 17цаг	11сарын дундуур	
	3 долоо хоногийн цахим сургалт					
	Хавар	2.10 – 2.28	1.3(Баасан)	1.7(Мягмар)	1 сарын дундуур	
	Зун	8.11 – 8.29	6.27(Баасан)	7.1(Мягмар)	7 сарын дундуур	
	13 долоо хоногийн солонгос хэлний сургалт		Визтэй хүмүүст зориулагдсан.			
	Хавар	3.3 – 5.30	1.24(Баасан)	1.31(Баасан) 17цаг	2 сарын дундуур	
	Намар	9.1 – 11.28	7.25(Баасан)	8.1(Баасан) 17цаг	8 сарын дундуур	
	Солонгос хэлний багш бэлтгэх сургалт	Хавар	3.3 – 6.9 (15 долоо хоног)	1.31(Баасан) 13цаг	2.3(Даваа)	
		Зун	6.30 – 8.6 (6 долоо хоног)	5.30(Баасан) 13цаг	6.2(Даваа)	
Намар		9.1 – 12.5 (15 долоо хоног)	8.1(Баасан) 13цаг	8.4(Даваа)		
Өвөл		2026.1.5 - 2.11(6 долоо хоног)	12.5(Баасан) 13цаг	12.8(Даваа)		

※Хэлний бэлтгэлийн нөхцөл байдлаас шалтгаалан зарим нэг төлөвлөгөө өөрчлөгдөж болно.

Оюутны байр

Хэлний бэлтгэлийн үндсэн сургалт(үдээс өмнөх болон үдээс хойших анги)-д бүртгүүлсэн суралцагчдад зориулан Сөүлийн Үндэсний их сургуулийн кампус дотор болон гадна оюутны байр ажиллуулж байна. Шинэ суралцагчдад байранд ороход давуу эрх олгодог ба хамгийн ихдээ 2 улирал(6 сар) оюутны байранд амьдрах боломжтой.

※ Сургалтын төлбөрийн данс болон оюутны байрны төлбөр төлөх данс өөр болно.

※ Сөүлийн Үндэсний их сургуулийн оюутны дотор байр(сургууль доторх) болон Хэлний бэлтгэлийн оюутны байр(сургуулийн гадна)-ны байршил болон тоног төхөөрөмж, зардал зэргийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Солонгос хэлний бэлтгэлийн цахим хуудас(lei.snu.ac.kr/lec)-аас харах боломжтой.

